



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/114

Мандалговь

“Топ дриллинг” ХХК-тай  
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/68 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах ажил”-ын багц-3 (Дундговь, Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Өндөршил сум) гүйцэтгэгчээр шалгарсан “Топ дриллинг” ХХК-тай 193,065,309 (нэг зуун ерэн гурван сая жаран таван мянга гурван зуун ес) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Стандартын дагуу “Инженерийн хийцтэй худаг шинээр барьж байгуулах ажил”-ын багц-3 (Дундговь, Гурвансайхан, Говь-Угтаал, Дэрэн, Өндөршил сум) чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Топ дриллинг” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Р.Батболд)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), Гурвансайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат), Говь-Угтаал сумын Засаг дарга (Ө.Мөнх-Амгалан), Дэрэн сумын Засаг дарга (Н.Мядагмаа), Өндөршил сумын Засаг дарга (Л.Мөнхбадрах) нарт, ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

482060514